



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/711

Булган сум

**Нийтийн номын сангийн үйлчилгээний
төрөл, үнэ тарифыг тогтоох тухай**

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Соёлын сайдын 2022 оны А/379 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 09 дүгээр албан даалгаврын дагуу "Улсын болон орон нутгийн номын сангийн нэмэлт үйлчилгээ үзүүлэх журам"-ын дагуу уншигчдын хэрэгцээ, үйлчилгээний цар хүрээнээс хамааран аймгийн Нийтийн номын сангийн нэмэлт үйлчилгээний төрөл болон төлбөрийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Нэмэлт үйлчилгээний төрөл, төлбөрийн тариф батлагдсантай холбогдуулан мэдээллийг номын сангийн мэдээллийн самбар, угтах үйлчилгээний цэг, уншигч бүртгэл, лавлагаа мэдээллийн хэсэг, цахим хуудаст уншигчдад харагдахуйц, ойлгомжтой, ил тод байршуулж, захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Нийтийн номын сангийн захирал (Т.Мөнгөнтуяа), хяналт тавьж ажиллахыг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга (Г.Алдармөнх)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

11
11
1/411
Аймгийн Засаг даргын 2025 оны
дүгээр сарын 06-ны/ний өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

Нийтийн номын сангийн үйлчилгээний төрөл, үнэ тариф

Д/д	Үйлчилгээний нэр, төрөл	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ
1	2	3	4
1	Уншигчийн карт (шинээр нээх, сунгах тухайн ондоо хүчинтэй)	1	5000₮
2	Номын хугацаа хэтрэлт	1 хоног	200₮
3	Ном хүргэлтийн үйлчилгээ	Зайнаас хамаарч	5,000₮-10,000₮
4	Хувилах, хэвлэх (хар)	1 нүүр	300₮
5	Хувилах, хэвлэх /өнгөт/	1 нүүр	500₮
6	Сканердах хэвлэх (хар)	1 нүүр	500₮
7	Сканердах хэвлэх (өнгөт)	1 нүүр	800₮
8	Зурагтай текст хэвлэх	1 нүүр	1500₮
9	Нуруулдах, хавтаслах	Хуудаснаас хамаарч	1000₮-3000₮
10	Ламинатор (бүрэх)	1 хуудас	500₮
11	Текст шивэх (A4)	1 нүүр	1000₮
12	Хүснэгт (A4)	1 нүүр	500₮
13	Интернэт үйлчилгээ	1 цаг	1000₮
14	Боловсролын хөтөлбөр хүүхэд хөгжлийн сургалт (хэрэглэгдэхүүнээс хамаарна)	2 цаг	10,000₮-30,000₮
15	Хурлын заал, танхим ашиглалт	1 цаг	50,000₮-80,000₮